



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай 1,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 70 16, Факс: (976-11) 32 70 16,
Цахим шуудан: stategreathural@parliament.mn,
Цахим хуудас: www.parliament.mn

2026.07.28 № 44

「Зам тээврийн ослын нөхцөл байдал,
түүнийг бууруулах талаар

Монгол Улсын Үндсэн хуульд иргэдийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах нь төрийн үндсэн үүрэг болохыг тунхагласан. Үндэсний их баяр наадмын үеэр авто замын хөдөлгөөн эрс нэмэгдэж, жил бүр зам тээврийн ослын улмаас олон иргэн амь насаа алдаж, эрүүл мэндээрээ хохирч байна.

Зам тээврийн ослын шалтгаан нь зөвхөн жолоочийн буруутай үйлдлээр хязгаарлагдахгүй бөгөөд замын инженерчлэл, хөдөлгөөний зохион байгуулалт, хяналт, замын нөхцөл, яаралтай тусламжийн хүртээмж зэрэг олон байгууллагын хамтын ажиллагаатай холбоотой асуудал юм. Иймд энэхүү асуудлыг Засгийн газрын түвшинд нэгдсэн байдлаар үнэлж, бодлогын шийдэл боловсруулах шаардлагатай байна.

Иймд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, 37 дугаар зүйлийн 37.1.2 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг тус тус үндэслэн, бүрэн эрхийнхээ хүрээнд дараах асуулгыг тавьж байна.

1.2026 оны Үндэсний их баяр наадмын амралтын өдрүүдэд улсын хэмжээнд бүртгэгдсэн зам тээврийн осол, түүнээс шалтгаалсан нас баралт, гэмтлийн дэлгэрэнгүй статистикийг аймаг, нийслэл, замын чиглэл, нас, хүйс, тээврийн хэрэгслийн төрлөөр гаргасан судалгаа;

2.2021–2025 оны баяр наадмын үеийн зам тээврийн ослын статистик, түүнд хийсэн дүн шинжилгээ;

3.Ослын үндсэн шалтгааныг ангилал тус бүрээр нь (хурд хэтрүүлсэн, согтууруулах ундаа хэрэглэсэн, гүйцэж түрүүлэх, ядаргаа, хамгаалах бүс, техникийн бүрэн бус байдал, замын нөхцөл, тэмдэг тэмдэглэгээ, мал амьтан, цаг агаар болон бусад) гаргасан тоо, хувь бүхий судалгаа;

4.Осол хамгийн их гардаг авто замын хэсгүүдийн эрсдэлийн үнэлгээ, өмнө хийсэн аудит, өгсөн үүрэг, хэрэгжилтийн талаарх мэдээлэл;

5.Баяр наадмын үеэр Засгийн газар, Цагдаа, Зам тээвэр, Эрүүл мэнд, Онцгой байдал болон орон нутгийн байгууллагуудаас зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, зарцуулсан төсөв, үр дүнг байгууллага тус бүрээр гаргасан мэдээлэл;

6. 2021-2025 оны дүн шинжилгээ, зөвлөмжийн хэрэгжилт болон 2026 онд ижил эрсдэл давтагдсан шалтгааны талаарх Засгийн газрын дүгнэлт;

7.Замын хөдөлгөөний аюулгүй байдлын удирдлага, холбогдох байгууллагуудын чиг үүргийн уялдаа, мэдээлэл солилцоо, хариуцлагын тогтолцоог сайжруулах чиглэлээр төлөвлөж буй шинэчлэлийн талаарх мэдээлэл;

8.2027 оноос баяр наадмын үеийн болон орон нутгийн авто замын осол, нас баралтыг бууруулах Засгийн газрын нэгдсэн бодлого, тусгай төлөвлөгөө, эрх зүйн шинэчлэл, хөрөнгө оруулалт, хэмжигдэхүйц зорилт, хэрэгжилтийн шалгуур үзүүлэлт.

Асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэгт заасан хугацаанд бичгээр ирүүлэх бөгөөд мөн зүйлийн 12.4 дэх хэсэгт заасны дагуу Улсын Их Хурлаар хэлэлцүүлэх болно.

Хүндэтгэсэн,

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН



Ж.БАЯРМАА

2026000128